

**МОНГОЛ УЛСЫН 2010 ОНЫ 5 ДУГААР
САРЫН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨВЧ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2010 оны 5 дугаар сарын гүйцэтгэлийн мэдээгээр нэгдсэн төсвийн нийт орлогын бүрдүүлэлт 120.0 хувийн биелэлттэй, нийт зарлага 83.9 хувийн гүйцэтгэлтэй гарч, төсвийн нийт алдагдал 169.8 тэрбум төгрөгт хүрсэн байгаа нь төлөвлөсөн дүнтэй харьцуулахад 391.4 тэрбум төгрөгөөр бага байна.

Нэгдсэн төсвийн орлого, зарлагын байдлыг авч үзвэл:

А. Нэгдсэн төсвийн орлогын бүрдүүлэлт:

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2010 оны 5 дугаар сарын гүйцэтгэлээр 1,002.1 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 166.7 тэрбум төгрөгөөр буюу 20.0 хувиар давж биелж, 2009 оны мөн үеийнхээс 58.3 хувиар буюу 369.0 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг орлогын төрлөөр авч үзвэл:

ТӨСВИЙН ОРЛОГО	НЭГДСЭН ТӨСӨВ						
	ӨО-ны мөн үеийн	жилийн Төлөв.	2010 ОНЫ 5-Р САР		ХУВЬ		ӨРҮҮ
	1	2	Төлөв. 3	Гүйцэт. 4	(4 : 3) 5	(4 : 2) 6	(4 - 3) 7
	(Тэрбум төгрөг)						
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	633.1	2,427.0	835.4	1,002.1	120.0	41.3	166.7
УРСГАЛ ОРЛОГО	632.2	2,403.4	829.4	968.7	116.8	40.3	139.3
ТАТВАРЫН ОРЛОГО	500.5	2,083.7	721.4	856.2	118.7	41.1	134.7
Орлогын албан татвар	129.7	698.6	244.7	302.6	123.6	43.3	57.9
ААН-ийн орлогын албан татвар	65.4	268.8	88.0	140.2	159.3	52.1	52.2
Хувь хүний орлогын албан татвар	45.5	119.2	47.0	53.5	113.9	44.9	6.5
Зарим үтгэгдэхүүний үнийн өсөлтийн татвар	18.7	310.6	109.8	108.9	99.2	35.1	-0.8
Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	89.6	278.6	103.1	112.3	108.9	40.3	9.2
Өмчийн татвар	3.6	10.5	3.7	4.2	114.0	39.6	0.5
Дотоодын бараа, үйлчилгээний татвар	183.2	696.0	241.9	277.7	114.8	39.9	35.7
Гадаад худалдааны орлого	42.5	153.1	51.6	60.5	117.2	39.5	8.9
Бусад татвар	52.1	246.8	76.4	99.0	129.5	40.1	22.5
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	131.6	319.7	108.0	112.6	104.3	35.2	4.6
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	0.9	1.6	1.5	1.5	99.1	91.8	0.0
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	0.0	22.0	4.6	31.9	0.0	145.0	27.4

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлог о татварын орлогоор 85.4 хувь, татварын бус орлогоор 11.2 хувь, тусламжийн орлогоор 3.2 хувь, хөрөнгийн орлогоор 0.2 хувь тус тус бүрдсэн үзүүлэлттэй байна.

Дэлхийн зах зээл дэх зэс, алтны үнэ төлөвлөсөн хэмжээнээс харьцангуй тогтвортой өндөр байсан, Татварын өрний газраас аж ахуйн нэгжүүдийн татварын өр барагдуулах ажлыг эрчимтэй зохион байгуулсан, татвартай барааны импортмнөх оноос 6 5.5 хувиар өссөн, АНУ -ын санхүү, эдийн засгийн хямралтай байгаа орнуудад үзүүлж буй тусламжийн хүрээнд манай улсад 14.5 тэрбум төгрөгийн мөнгөн тусламжийг нийгмийн халамжийн санхүүжилтэд зориулан олгосон зэрэг нь нэгдсэн төсвийн орлого төлөвлөгөөнөөс давж биелэхэд нөлөөлсөн байна.

Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг төсвийн бүрэлдэхүүнээр харуулбал:

ТӨСВИЙН ОРЛОГО	Улсын өсөв		Орон нутгийн өсөв		ХХС		НДС	
	ТӨЛ	ГҮЙ	ТӨЛ	ГҮЙ	ТӨЛ	ГҮЙ	ТӨЛ	ГҮЙ
	(Тэрбум.өгрөг)							
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	669.3	799.2	108.0	119.3	24.1	41.0	198.8	205.3
УРСГАЛ ОРЛОГО	601.0	706.2	97.8	109.2	24.1	41.0	131.6	138.1
ТАТВАРЫН ОРЛОГО	502.4	600.2	91.9	102.7	24.1	41.0	131.6	138.1
Орлогын албан татвар	197.8	249.1	47.0	53.5	0.0	0.0	0.0	0.0
ААН-ийн орлогын албан татвар	88.0	140.2	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Хувь үний орлогын албан татвар	0.0	0.0	47.0	53.5	0.0	0.0	0.0	0.0
Зарим ҮТээгдэхүүний үнийн өсөлтийн а/татвар	109.8	108.9	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	131.6	138.1
Өмчийн татвар	0.0	0.0	3.7	4.2	0.0	0.0	0.0	0.0
Дотоодын бараа, үйлчилгээний татвар	234.2	270.2	7.8	7.5	0.0	0.0	0.0	0.0
Гадаад худалдааны орлого	51.6	60.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бусад татвар	18.9	20.4	33.4	37.5	24.1	41.0	0.0	0.0
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	98.6	106.0	5.9	6.5	0.0	0.0	0.0	0.0
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	0.0	0.0	1.5	1.5	0.0	0.0	0.0	0.0
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	68.3	93.0	8.7	8.7	0.0	0.0	67.3	67.3

- Улсын төсвийн орлого 799.2 тэрбум өгрөгт хүрч 19.4 хувиар буюу 129.9 тэрбум төгрөгөөр төлөвлөгөөнөөс давж биелсэн байна. Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын орлого 59.3 хувиар буюу 52.2 тэрбум, нэмэгдсэн өртгийн албан татварын орлого 25.8 хувиар буюу 38.7 тэрбум, гадаад худалдааны орлого 17.2 хувиар буюу 8.9 тэрбум, татварын бус орлого 7.5 хувиар буюу 7.4 тэрбум, тусламжийн орлого 36.2 хувиар буюу 24.7 тэрбум төгрөгөөр тус тус давж биелсэн байна.
- Орон нутгийн төсвийн орлого 119.3 тэрбум төгрөгт хүрч, 10.5 хувиар буюу 11.4 тэрбум төгрөгөөр төлөвлөгөөнөөс илүү төвлөрсөн байна. Сэлэнгэ аймгийн орлого 1.7 тэрбум, Орхон аймгийн орлого 1.6 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөгөөнөөс давж биелсэнд тус аймгуудын ашигт малтмалын юөц ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэл нөлөөлсөн байна. Нийслэлийн авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн татварын орлого 0.7 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн хэдий ч хувь хүний орлогын албан татварын орлого 2.4 тэрбум, өмчийн татварын орлого 0.4 тэрбум, тус тус төлөвлөгөөнөөс давж биелсэн, хүн амын орлогын албан татварын буцаалтаар 2.3 тэрбумийг буцаан олгохоор төлөвлөснөөс тайлант хугацаанд багтааж олголт хийгдээгүй зэргийн дүнд нийт орлого 6.4 тэрбум төгрөгөөр төлөвлөгөөнөөс давсан байна.
- Хүний хөгжлийн санд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого 41.0 тэрбум төгрөг төвлөрсөн нь төлөвлөгөөнөөс 49.1 хувиар буюу 13.5 тэрбум төгрөгөөр илүү байна. Нийгмийн даатгалын сангийн орлого 205.3 тэрбум төгрөгт хүрч, 3.3 хувиар буюу 6.5 тэрбум төгрөгөөр орлогын төлөвлөгөө давж биелсэн байна. Нийгмийн даатгалын санд улсын өсвөөс олгох 67.3 тэрбум өгрөгийн татаас олгохоор төлөвлөснийг бүрэн санхүүжүүлсэн байна.

Б. Нэгдсэн төсвийн зарлага, санхүүжилт:

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага 2010 оны 5 дугаар сарын гүйцэтгэлээр 1,396.6 тэрбум өгрөг, үүнээс улсын төсвийн зарлага 1,047.3 тэрбум өгрөг байхаар төлөвлөгдсөнөөс гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн зарлага 1,171.9 тэрбум өгрөг болж,

төлөвлөгдсөн нийт зарлага 83.9 хувийн, улсын төсвийн зарлага 858.4 тэрбум төгрөг болж, нийт төлөвлөгдсөн зардал 82.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Халамжийн сангаас халамжийн тэтгэвэр, тэтгэмжид 22.8 тэрбум, алдар цолтой ахмад, ахмад дайчдад олгох өнгөлөлтөд 3.5 тэрбум, жирэмсэн нярай эхчүүдэд олгох санхүүжилтэд 7.9 тэрбум, алдарт эхийн одонт эхчүүдэд олгох тусламжид 8.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон байна.

Орон нутгийн төсвийн зарлага 103.2 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгдсөн нийт зардал 85.7 хувийн гүйцэтгэлтэй байна. Хүний хөгжлийн сангаас иргэдэд олгох бэлэн өнгөнд зориулж 179.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон. Нийгмийн даатгалын сангийн өлөвлөгдсөн зардал 94.0 хувийн буюу 190.3 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Нэгдсэн төсвийн зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл

ТӨСВИЙН ЗАРЛАГА	НЭГДСЭН ТӨСӨВ						
	ӨО-ны	жилийн	2010 ОНЫ 5-Р САР		ХУВЬ		ӨРҮҮ
	мон үеийн	Төлөв.	Төлөв.	Гүйцэт.	(4:3)	(4:2)	(4-3)
	1	2	3	4	5	6	7
	(Тэрбум төгрөг)						
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	824.9	2,785.6	1,396.6	1,171.9	83.9	42.1	-224.7
УРСГАЛ ЗАРДАЛ	702.4	2,170.7	1,044.2	912.9	87.4	42.1	-131.3
Бараа, үйлчилгээний зардал	377.1	1,053.0	488.9	420.0	85.9	39.9	-69.0
Цалин хөлс	230.7	599.0	250.2	242.9	97.1	40.5	-7.3
Нийгмийн даатгалын шимтгэл	21.0	57.3	23.9	22.1	92.4	38.6	-1.8
Бараа, үйлчилгээний бусад зардал	146.4	454.1	238.7	177.1	74.2	39.0	-61.6
Зээлийн үйлчилгээний төлбөр	11.4	42.8	16.0	14.0	87.5	32.6	-2.0
Татаас ба шилжүүлэг	313.9	1,074.8	539.3	478.9	88.8	44.6	-60.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	77.2	518.5	287.8	133.0	46.2	25.7	-154.8
Дотоод эх үүсвэрээр:	67.2	480.2	281.9	131.7	46.7	27.4	-150.2
Гадаад эх үүсвэрээр	10.0	38.2	5.8	1.3	21.6	3.3	-4.6
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	45.3	96.4	64.6	126.0	195.0	130.7	61.4
УРСГАЛ ТЭНЦЭЛ	-70.2	232.7	-214.8	55.9	(26.0)	24.0	270.6
НИЙТ ТЭНЦЭЛ	-191.8	-358.6	-561.1	-169.8	30.3	47.3	391.4

Эргэж төлөгдөх цэвэр зээл :

Монгол Улсын Засгийн газар 2010 оны эхний 5 сард олон улсын байгууллага, гадаадын хандивлагч орнуудаас 67.8 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний төслийн зээлийн хөрөнгийг авч ашиглахаар төлөвлөсөн бөгөөд тайлант хугацаанд 21.2 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний эх үүсвэрийг авч ашигласан байна. Иргэдэд олгох бэлэн мөнгөний дэвтэр хэвлүүлэхэд зориулж 875.4 сая өгрөг, гадаад паспорт хэвлүүлэхэд зориулж 240.0 сая төгрөгийн зээлийг улсын төсвөөс олгосон байна. Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хуулийн дагуу Зоос банкин дахь өнгөн хөрөнгөд баталгаа болгож Засгийн газрын 33.0 тэрбум төгрөгийн бондыг Монголбанкинд, Төрийн банкны актив, пассивын зөрүүг тэнцүүлэх зорилгоор 67.0 тэрбум төгрөгийг Төрийн банкинд арилжаалсан байна. Мөн төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах “4000 орон сууц” өгөлбөрийг хэрэгжүүлэхээр 12.0 тэрбум өгрөгийн Засгийн газрын бондыг арилжиж, бондын эхүүсвэрийг Орон сууцны санхүүжилтийн корпорацид дамжуулан зээлдүүлээ.

Төсвийн тэнцэл:

Тайлант үед Монгол Улсын нэгдсэн төсвийн урсгал тэнцэл 55.9 тэрбум өгрөгийн ашигтай, нийт тэнцэл 169.8 тэрбум төгрөгийн алдагдалтай, улсын төсвийн урсгал тэнцэл 98.5 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 59.2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

ОУВСангаас хэрэгжүүлж байгаа “Стэнд бай” хөтөлбөрийн хүрээнд төлбөрийн тэнцлийг сайжруулах зорилгоор 32.7 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний зээл элжих тусгай эрхийг ОУВСангаас Монголбанк дахь улсын төсвийн харилцах дансанд байршуулсны дагуу улсын төсвөөс Монголбанк дахь ОУВСангийн үнэт цаасны дансанд тэнцэх хэмжээний төгрөгийн байршуулсан. Уг хөрөнгийг Монголбанкинд Засгийн газрын бонд арилжаалах з амаар бүрдүүлсэн болно.

Тайлант хугацаанд гадаад зээлийг үндсэн төлбөрт 23.3 тэрбум өгрөгийг төлж, 21.2 тэрбум төгрөгийн зээлийг авч ашигласан байна.

Монгол Улсыг өгжүүлэх сангийн 2009 оны мөнгөн хөрөнгийн үлдэгдэл болох 134.1 тэрбум өгрөгийг улсын төсвийн харилцах дансанд шилжүүлэн 2010 оны улсын төсвийн зарлагын эх үүсвэр болгосон.

-----oOo-----